

БАТЛАВ:
ЖАРГАЛАНТ СУМЫН ЗАСАГ
ДАРГА С.ГАНТӨМӨР

**ЖАРГАЛАН СУМ ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗАР**

**ЖИШИГ ГУДАМЖ ТОХИЖУУЛАХ /ЖАРГАЛАНТ СУМ, НАРАН БАГ/
АЖЛЫН ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ**

Тендер шалгаруулалт/
гэрээний нэр, дугаар:

**Баатархайрхан өрхийн ЭМТ-ийн барилгыг цэвэр,
бохирын шугамтай холбох /Жаргалант сум/**

ХОАОНӨГ/202001155

**Ховд
2020 он**

**[ХОВД АЙМГИЙН ЖАРГАЛАНТ СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР]**

Огноо: 2020.05.22

**БААТАРХАЙРХАН ӨРХИЙН ЭМТ-ИЙГ ЦЭВЭР,
БОХИРЫН ШУГАМД ХОЛБОХ /ЖАРГАЛАНТ СУМ/
АЖЛЫН
ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ**

Төслийн нэр: БААТАРХАЙРХАН ӨРХИЙН ЭМТ-ИЙН БАРИЛГЫН ЦЭВЭР,
БОХИРЫН ШУГАМД ХОЛБОХ /ЖАРГАЛАНТ СУМ/

Төслийн дугаар: ХОАОНӨГ/202001155

**Тендер шалгаруулалт
/ гэрээний нэр:** БААТАРХАЙРХАН ӨРХИЙН ЭМТ-ИЙН БАРИЛГЫН ЦЭВЭР,
БОХИРЫН ШУГАМД ХОЛБОХ /ЖАРГАЛАНТ СУМ/
ХОАОНӨГ/202001155

2020.05.22

Ховд аймгийн Жаргалант сумын Засаг даргын тамгын газар нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос **Баатархайрхан өрхийн ЭМТ-ийн барилгыг цэвэр, бохирын шугамд холбох /Жаргалант сум/ ажил** гүйцэтгэх тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Үнийн санал ирүүлэх ажлын зураг, техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг хавсаргасан болно.

Үнийн саналыг **2020 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн Улаанбаатарын цагаар 11 цаг 00 минут байна.** -аас өмнө **Ховд аймаг, Жаргалант сумын Засаг даргын Тамгын газрын байр, 107 тоот өрөөнд** (www.tender.gov.mn) хаягаар өөрийн аж ахуйн нэгжийн цахим гарын үсэг (PKI)-ээр нэвтрэн орж баримт бичгээ (Adobe PDF) шилжүүлж цахим хэлбэрээр ирүүлнэ.

Үнийн саналыг нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан **Тендерийг 2020 оны 05 дугаар сарын 28-ны өдөр Улаанбаатарын цагаар 11 цаг 40 минутад Ховд аймаг, Жаргалант сумын Засаг даргын Тамгын газрын байр, 107 тоот өрөөнд нээнэ.**

Дотоодны давуу эрх тооцох эсэх. **Тооцохгүй**

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Ховд аймгийн Жаргалант сумын Бичигт баг Жаргалант сумын Засаг даргын тамгын газрын байр, 1 давхар 107 тоот утас: 7043-5285

Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- 1. Эрх бүхий тендерт оролцогч**
 - 1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
- 2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт**
 - 2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.
 - 2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.
- 3. Тендерийн иж бүрдэл**
 - 3.1. Тендерт оролцогчдод өгсөн зааварчилгааны дагуу бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ:
 - (а) Үнийн санал;
 - (б) Үнэлэгдсэн үе шатны ажлын хуваарь;
 - (в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
 - (г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;
 - (д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.]
- 4. Тендерийн үнэ**
 - 4.1. Тендерийн үнэд тодорхойлсон нийт ажил хамрах ба тендерт оролцогчийн үнэлж ирүүлсэн үе шатны ажлын хуваарьт үндэслэнэ.
 - 4.2. Тендерт оролцогч үнийн хөнгөлөлтийг тендерт тусган санал болгож болно.
 - 4.3. Тендерт оролцогч нь зураг болон техникийн тодорхойлолтод тодорхойлогдсон ажлыг үнэлэхдээ үе шатны ажлын хуваарьт хураангуй байдлаар өгөгдсөн бүх нэр төрөлд нэгж үнэ болон нийт үнэ санал болгоно. Тендерт оролцогч аль нэг нэр төрлийн нэгж үнэ болон нийт үнийг бөглөөгүй орхисон тохиолдолд түүнийг гүйцэтгэсний төлбөрийг захиалагч хийхгүй ба бусад нэр төрлийн үнэд багтсан гэж үзнэ.
 - 4.4. Тендерт оролцогч нь тендер хүлээн авах эцсийн хугацаанаас 14 хоногийн өмнө хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийн дагуу энэ гэрээ болон бусад үндэслэлээр гүйцэтгэгчийн төлөх ёстой бүх татвар, хураамж, бусад төлбөрийг тендерийн нийт үнэд багтаасан байна.
- 5. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа**
 - 5.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш **45** хоногийн хугацаанд хүчинтэй байна.
- 6. Алдааг залруулах**
 - 6.1. Захиалагч шаардлагад нийцсэн тендерийн арифметик алдааг шалгаж дараах байдлаар залруулна:
 - (а) тоо болон үсгээр илэрхийлэгдсэн дүн хоорондоо зөрсөн бол үсгээр илэрхийлэгдсэнийг зөв гэж үзнэ;

- (б) үе шатны ажлын үнийн нийлбэр тендерийн маягтад заасан тендерийн нийт үнээс зөрвөл үе шатны ажлын үнийн нийлбэрийг үндэслэн тендерийн нийт үнийг залруулна;
- (в) нэгж үнийг ажлын тоо хэмжээгээр үржүүлж гаргасан нэг мөр дэх нийт дүнд зөрүү гарвал нэгж үнийг давамгайлах гэж үзнэ. Гэхдээ захиалагчийн үзэж байгаагаар нэгж үнэд аравтын орны таслалыг андуурсан болох нь илэрхий байвал тухайн мөр дэх нийт дүнг зөв гэж үзэн холбогдох нэгж үнийг залруулна.

6.2. Захиалагчийн залруулсан тендерийн дүнг тендерт оролцогчийн зөвшөөрлөөр эцсийнх гэж үзнэ. Хэрэв тендерт оролцогч залруулсан дүнг хүлээн зөвшөөрөхгүй бол захиалагч түүний тендерээс татгалзана.

7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх

- 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
- 7.2. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдийн үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.

8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл

- 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө утсан холбоогоор мэдэгдэж, албан бичгээр баталгаажуулна. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

Гурав. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

| ТӨӨЗ-ны холбогдох заалт | Шалгуур үзүүлэлт |
|-------------------------|--|
| ТӨӨЗ 1.1 | <p>Тендерт оролцогч нь Аймагас эрх шилжиж ирсэн 30,0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Ховд аймгийн Жаргалант сумын Баатархайрхан өрхийн ЭМТ-ийн барилгыг цэвэр, бохирын шугамтай холбох ХОАОНӨГ/202001155 дугаартай ажлыг гүйцэтгэх үнийн саналыг дараах мэдээллийн хамт ирүүлнэ. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Аж ахуйн нэгжийн гэрчилгээний хуулбар 2. 2019 оны санхүүгийн тайлан аудитын дүгнэлтийн хамт; 3. Борлуулалтын орлогын нийт мөнгөн дүнгийн жилийн дундаж: Сүүлийн 2 жилийн дундаж нь 10,000,000 төгрөгнөөс багагүй байна. 4. Татварын тодорхойлолт (татварын бар код бүхий тодорхойлолт), 5. Шүүхийн тодорхойлолт 6. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын тодорхойлолт 7. Харилцагч банкны тодорхойлолт, 8. Нийгмийн даатгалын байгууллагын тодорхойлолт /шимтгэлийн өртэй эсэх, нийгмийн даатгалд шимтгэл төлдөг хүмүүсийн жагсаалт/, 9. Ажлын төсөв ирүүлнэ /зураг төсвийн үнэ 200,000 төгрөгийг тусгана/ 10. Авах боломжтой зээл, эргэлтийн хөрөнгийн нийт дүн: Төсөвт өртөгөөс дээш. 11. Тендерт оролцогч гэрээг гүйцэтгэхэд зайлшгүй шаардлагатай үндсэн тоног төхөөрөмж, машин механизмууд: <ul style="list-style-type: none"> - Ачааны машин / Үйлчилгээний машин/ - Шаардлагатай багаж хэрэгсэл -Шаврын тогоо /цахилгаан/ <p>Дээрхи дурдсан машин механизмын тээврийн хэрэгслийн гэрчилгээг нотариатаар баталгаажуулан ирүүлэх. Түрээсийнх бол түрээсийн гэрээ ирүүлнэ.</p> <ol style="list-style-type: none"> 12. Албан мэдэгдэл /ТӨӨЗ-нд заасан/ Байгууллагын тодорхойлолтуудыг тендер зарласан өдрөөс хойш гаргасан байна. 13. Ажил гүйцэтгэх хугацааны график ирүүлнэ. 14. Тендерт оролцогч тухайн ажилд шаардлагатай дараах зөвшөөрөлтэй байна. Үүнд: Зам тээвэр, Барилга хот байгуулалтын яамны <ol style="list-style-type: none"> 2.2.1. барилга байгууламжийн доторх халаалт, салхивч, усан хангамж, ариутгалын татуургын шугам сүлжээ, тэдгээрийн тоног төхөөрөмж, гадна салбар шугам сүлжээний угсралт, 15. Ажлын төсөв ирүүлэх 16. Сүүлийн 2 жил ижил төстэй хийж гүйцэтгэсэн ажлын гүйцэтгэл, акт, гэрээний үүргийн биелэлт |

| | |
|------------------------|--|
| <p>ТӨӨЗ 2.1</p> | <p>Тендер хүлээн авах хаяг, Ховд аймгийн Жаргалант сумын Бичигт баг Жаргалант сумын Засаг даргын тамгын газрын байр, 1 давхар 107 тоот</p> <p>Тендер хүлээн авах этгээд: Уг тендэр нь цахим тендерийн журмаар явагдаж байгаа тул тендэрт оролцогч нь Цахим худалдан авах ажиллагааны систем (www.tender.gov.mn) хаягаар өөрийн аж ахуйн нэгжийн цахим гарын үсэг (PKI)-ээр нэвтрэн орж баримт бичгээ (Adobe PDF) шилжүүлж цахим хэлбэрээр ирүүлнэ.</p> <p>Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь 2020 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн Улаанбаатарын цагаар 11 цаг 00 минут байна.</p> |
| <p>ТӨӨЗ 2.1</p> | <p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь: Тендерийг 2020 оны 05 дугаар сарын 28-ны өдөр Улаанбаатарын цагаар 11 цаг 40 минутад Ховд аймаг, Жаргалант сумын Засаг даргын Тамгын газрын байр, 107 тоот өрөөнд нээнэ. Харилцах утас: 7043-5285</p> |
| <p>ТӨӨЗ 6.2</p> | <p>Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: Багцгүй</p> |

БАТЛАВ: ЖАРГАЛАНТ СУМЫН ЗАСАГ ДАРГА

С: ГАНТӨМӨР

**Ховд аймаг Жаргалант сум Баатархайрхан багийн Өрхийн эрүүл мэндийн төвийг
цэвэр усны шугамтай холбох ажлын тоо хэмжээ**

| д/д | АЖИЛБАР | Хэмжих нэгж | Ажлын тоо | Ажлын тайлбар |
|-----|------------------------|-------------|-----------|--|
| 1 | Ф100 HDPE хоолой | м | 110 | HDPE 1.6 мПа хоолой байна. Хөлдөлтийн гүнээс доогуур хийнэ. 3,2 метрээс доош гүнд ухаж хийнэ. Шугамыг дулаалсан байна. |
| 2 | Ф50 HDPE хоолой | м | 10 | HDPE 1.6 мПа хоолой байх, хөлдөлтийн гүнээс доогуур хийнэ. 3,2 метрээс доош гүнд ухаж хийнэ. Шугамыг дулаалсан байна. |
| 3 | Ф1500 кольцо | ш | 12 | Цэвэр усны худгийг Ф1500 кольцогоор угсарах ба ус чийгнээс хамгаалах тосон түрхлэг 2 үе хийж өгнө. |
| 4 | Ф1500 ташуу таг | м | 4 | Худгийн кольцотой двутавраар бэхлэсэн байна. |
| 5 | Ф1500 ул бетон | ш | 4 | Хөрстэй харьцах хэсэгт ус чийгнээс тусгаарлах тосон түрхлэг хийнэ. |
| 6 | Ф700 хүзүүвч кольцо 1м | | 4 | Кольцоны гадна хэсэгт ус чийгнээс хамгаалах тосон түрхлэг хийнэ. |
| 7 | Ф700 ширмэн таг | м | 4 | Хүзүүвчтэй бэхэлж цутгамал бетонон гагнаас хийж бат бэхийг шалгана. |
| 8 | Дулаалагатай модон таг | ш | 4 | Дулаан алдагдалгүй материалаар хийнэ. |
| 9 | Ф100 хаалт | | 1 | Фланец зэргээр тоноглоно. |
| 10 | Ф50 хаалт | м | 1 | Фланец зэргээр тоноглоно. |
| 11 | Ф100-50 шилжвэр | ш | 1 | Угсралтын горимыг баримталж угсарна. |
| 12 | Төмөр шат 3м | ш | 4 | Худгийн хананд гагнаж бэхлэнэ. Бат бэхийг шалгана. |
| 13 | Хашаа блок өрөх | м | 20 | Эмнэлэг болон 2 айлын хашааны блокыг буулгаж хийнэ. Ажил дууссаны дараа блокыг өрөж өмнөх байдалд оруулсан байна. |

**Ховд аймаг Жаргалант сум Баатархайрхан багийн Өрхийн эрүүл мэндийн төвийг
Бохир усны шугамтай холбох ажлын тоо хэмжээ**

| Д/д | АЖИЛБАР | Хэмжих нэгж | Ажлын тоо | Ажлын тайлбар |
|-----|-------------------|-------------|-----------|---|
| 1 | Ф150 шугам | м | 64 | UPVC 1.6 мПа хоолой байна. Хөлдөлтийн гүнээс доогуур буюу 3,2 метрээс дээш гүнд ухаж хийнэ. Шугамыг хөлдөхгүйгээр маш сайн дулааласан байна. /урсах чигт i=0.007м налууутай / |
| 2 | Ф100 шугам | м | 26 | UPVC 1.6 мПа хоолой байна. Хөлдөлтийн гүнээс доогуур буюу 3,2 метрээс дээш гүнд ухаж хийнэ. Шугамыг хөлдөхгүйгээр маш сайн дулааласан байна. /урсах чигт i=0.007м налууутай/ |
| 3 | Ф1000 кольцо 1м | ш | 4 | Бохир усны худгийг Ф1000 кольцоогоор угсарах ба ус чийгнээс хамгаалах тосон түрхлэг хийх, ф700 кольцоогоор хүзүүвч хийж шат зэргээр тоногдосон байна. |
| 4 | Ф1000 ул бетон | ш | 2 | Хөрстэй харьцах хэсэгт ус чийгнээс тусгаарлах тосон түрхлэг 2 үе хийнэ. |
| 5 | Ф1000 ташуу таг | ш | 2 | Худгийн кольцотой двугавраар бэхлэнэ. |
| 6 | Ф700 кольцо 1м | ш | 2 | Кольцоны гадна хэсэгт ус чийгнээс хамгаалах тосон түрхлэг 2 үе хийнэ. |
| 7 | Ширмэн таг | ш | 2 | Хүзүүвчтэй бэхэлж цутгамал бетонон гагнаас хийсэн байна. |
| 7 | Ширмэн таг | ш | 2 | Хүзүүвчтэй бэхэлж цутгамал бетонон гагнаас хийсэн байна. |
| 8 | Төмөр шат 2м | ш | 2 | Худгийн хананд гагнаж бэхлэнэ. Бат бэхийг шалгана. |
| 9 | Хашааны блок өрөх | м | 40 | Эмнэлэгийн хашааны блокыг буулгаж хийнэ. Ажил дууссаны дараа блокыг шавардаж, өрөж өмнөх байдалд оруулсан байна. |

ӨЭМ-ын төвийг цэвэр усны шугаманд холбоход хийгдэх ажлууд:

Баатархайрхан багийн өрхийн эмнэлэгийг цэвэрт холбоход 2 айлын хашаагаар дайрч хийгдэнэ. Айлын хашаагаар дайран газар ухагдаа байшингийн хундаамд нөлөө үзүүлэхгүйгээр аюулгүй байдлыг чандлан сахиж хамгаалах тулгуур хийнэ ажиллана. Нийт 40 метр хашааны блокыг буулгаж хийнэ. Ажил дууссаны дараа блокыг өрөж өмнөх байдалд оруулж өгсөн байна. Дамжин өнгөрч байгаа 2 айлын хашаанд худаг гаргаж өгнө. Угсралтыг дууссаны дараа шугам сүлжээний битүүмжийг шалгаж 6 ата даралтаар 30 минутын турш (хий) даралтаар шалгана хэрвээ 30 минут турш даралтыг бариулахад 0,5 ата даралтаар унахыг зөвшөөрнө. Энэ бүх үйл явцыг ил далд ажлын актаар баталгаажуулана.

Шаардлага

1. Гүйцэтгэгч нь ажлын талбайд гэрээ байгуулсаны дараа 3 хоногийн дотор Компаний товч танилцуулга, харилцах утас, гүйцэтгэж байгаа ажлын нэр, гэрээний дүн, ажил эхлэх болон дуусах хугацаа зэргийг багтаасан мэдээллийн самбарыг олон нийтэд үзэгдэхүйц газар байрлуулсан байна.

2. Гүйцэтгэгч нь ашиглагч, захиалагч байгууллагуудтай уялдаатай ажиллах бөгөөд гэрээнд заасан хугацаан дотор ажил гүйцэтгэх хуваарийг боловсруулж ирүүлнэ.

3. Гүйцэтгэгч үе шатны ажлын үед зохиогч болон захиалагчийг дуудаж далд ажлын акт үйлдэж баталгаажуулна.

4. Ажлын тоо хэмжээг гэрээний ерөнхий болон тусгай нөхцөл, техникийн тодорхойлолт болон зурагтай холбож ойлгоно.

5. Ажлын тоо хэмжээнд тодорхойлсон магадлашгүй ажлын зардлыг зарцуулахад захиалагчийн зөвшөөрөл баталгааг авна.

6. Үндсэн ажлын тоо хэмжээнд тусгагдсан үнэ өртөгийн ажлын тоог заасан заагаагүй, аль ч нөхцөлд тодорхойлсон байна. Гүйцэтгэгчийн бөглөөгүй орхисон үнэ өртөг, тодорхойлоогүй үлдээсэн ямар нэгэн ажил, түүний үнэ өртөг нь ажлын хэмжээнд тусгагдсан бусад ажлуудад шингэсэн гэж ойлгоно.

7. Гүйцэтгэгч нь ажилтнууддаа хамгаалах хэрэгслээр бүрэн хангаж, тухайн орчин, ажлын байр, зам гарц, талбайг хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны дүрэмд заасны дагуу бэлтгэж, үйлдвэрийн ослоос уридчилан сэргийлэх арга хэмжээг авч, хашаа хамгаалалт байгуулж, оршин суугчдийн зорчих хэсгийг техникийн аюулгүй ажиллагааны нөхцлийг бүрэн хангаж ажиллах ба үүнээс гарах хор хохирлыг өөрсдөө хариуцна. Байгалийн гэнэтийн гамшиг, гал түймэр, үер усны гамшигаас сэргийлэн аюулгүй байдлыг бүрэн хангаж ажиллана.

8. Ажлыг гүйцэтгэх үед тухайн орчны тохижилт, холбоо, цахилгаан, интернетийн кабель утсыг гэмтээсэн тохиолдолд гүйцэтгэгч өөрийн хөрөнгөөр түргэн шуурхай засварлан хангагч байгууллагад хүлээлгэн өгнө.

9. Тухайн гүйцэтгэсэн ажилдаа Барилгын тухай хуулийн 14.3, 14.6 дахь заалтуудын дагуу тохируулга, ашиглалтын хугацааны баталгааг бичгээр гаргаж ирүүлнэ.

10. Барилга байгууламжийн инженерийн шугам сүлжээний засвар, ашиглалтын хугацааны жишиг норм БНБД 13 04 03 дагаж мөрдөнө.

11. Барилга угсралтын ажлыг мөрдөх хөдөлмөр хамгааллын үлгэрчилсэн заавар БНБД 12 101.05 дагаж мөрдөнө.

Хянасан: Дэд бүтэц


хариуцсан орлогч дарга:



Ц.Цогтбаяр

Боловсруулсан: Хотын захирагчийн

ажлын албаны мөргөжилтэн:




Г.Тунгалаг

**Баатархайрхан багийн ӨЭМ-н төвийг цэвэр бохирын
шугам сүлжээнд холбох схем зураг**



ТАНИХ ТЭМДЭГ

- | | | | |
|--|------------------------------|--|--|
| | Төлвлөж буй бохир усны шугам | | Шинээр зураг төсөл хийгдсэн бохир усны шугам |
| | Төлвлөж буй цэвэр усны шугам | | Шинээр зураг төсөл хийгдсэн цэвэр усны шугам |
| | Одоо байгаа бохир усны шугам | | Одоо байгаа цэвэр усны шугам |

БАТЛАВ:  Т.БААТАРЗОРИГ /НААУ-ний "Шим-Ус" ОНӨААТҮГ-ын ДАРГА/

ТЕХНИКИЙН НӨХЦӨЛ

2020 он...⁰⁵ сар...⁰⁵ өдөр

№.../11

Жаргалант сум

1.Хэрэглэгчийн нэр, хаяг: Жаргалант сумын Засаг даргын Тамгын газар, Ховд аймаг, Жаргалант сум

2.Техникийн нөхцөл олгох үндэслэл: Баатархайрхан өрхийн эрүүл мэндийн төвийн барилга

3.Холбогдох цэгүүд: Ус хангамж: Үйлдвэрийн раойны цэвэр усны шугамнаас Ф100 стандарт шугам хоолойгоор татаж холбоно. Мухардмал шугам учраас хөлдөлтийн гүнийг тооцон, дулаалгыг сайтар ороож угсарна.

Ариутгах татуурга: Урд чиглэлийн бохир усны төв шугамд Ф150 стандартын хуванцар шугам хоолойгоор 1 метрт 0,007-0,01 мм налуутайгаар хөлдөлтийн гүнээс доош гүнд, цэвдэгшилтээс хамгаалан дулаалгыг сайтар ороож угсарна.

4.Тоолуур: Барилгын халуун хүйтэн усны шугамын оруулгад баталгаажуулсан тоолуурыг тусгай зөвшөөрөлтэй байгууллагаар суурилуулна.

5.Тусгай заалтууд: "Хот суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай" хуулийн 17.7-д /хотын доторх цэвэр усны дамжуулах түгээх, бохир усны гаргалгааны болон бохир ус цуглуулах, татан зайлуулах шугам ашиглалтын явцад засвар, үйлчилгээ хийх хамгаалалтын зурвас газартай байх/, 17.6 /төвлөрсөн ус хангамжийн дамжуулах, түгээх шугамын тэнхлэгээс хоёр тийш таван метрт хамгаалалтын зурвас тогтооно/, 17.14-д /бохир ус татан зайлуулах шугамын тэнхлэгээс хоёр тийш зургаан метрээс багагүй зайд барилга байгууламж, шугам сүлжээг барихыг хориглоно/ зэрэг заалтуудыг мөрдөж ажиллана.

- Ус хангамж, ариутгах татуургын магистрал шугам сүлжээнээс 5 метрийн газар нь нийтийн эзэмшлийн бүс болохыг анхааруулж байна. Барилгын норм ба дүрэм 3.05.04-09-ийн дагуу хийнэ.

- Барилгын бохир усны шугамын гаргалгаанд үл буцах хаалт тавина.

- Ус хангамж, ариутгах татуургын гадна шугамыг угсрахдаа хязгаарлах туузыг шугамын оройгоос 20 см-т байхаар байрлуулж өгнө.

Хүчинтэй хугацаа 1 жил

- Ус хангамж, ариутгах татуургын гадна шугам сүлжээг тусгай зөвшөөрөлтэй орон нутгийн компаниар гүйцэтгүүлнэ.

Комиссын дарга:  М.Нансалмаа /Ерөнхий инженер/
Гишүүд:  О.Балжинням /Ус хангамжийн инженер/
 О.Киват /Ариутгах татуургын техникч/
 П.Азаяа /Ахлах сантехникч/
 Б.Батхишиг /Цэвэр усны шугамын засварчин/

Хүчинтэй хугацаа 1 жил

Тав.. ҮЕ ШАТНЫ АЖЛЫН ХУВААРЬ

| Үе шатны ажлын нэр | Ажлын тодорхойлолт | Тоо ширхэг | Хэмжих нэгж | ТШӨХ-д заасан (Ажлын талбай) | Ажил хийж дуусгах хугацаа | | |
|--------------------|--------------------|------------|-------------|------------------------------|----------------------------------|----------------------------|---|
| | | | | | Ажил эхлэх хамгийн эхний хугацаа | Ажил дуусах эцсийн хугацаа | Нийлүүлэгчийн санал болгосон хугацаа (Тендерт оролцогч энэ баганыг бөглөнө) |
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| | | | | | | | |

Хийгдэх ажлын байршлийн зураг



Зургаа. **ЖИШИГ МАЯГТ**

ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга _____ танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр], [гэрээний нэр ба дугаар]-ыг [тендерийн үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр тендерийн баримт бичгийн дагуу гүйцэтгэхээр санал болгож байна.
2. Тендер нь тендерийн баримт бичигт заасны дагуу тендер хүлээн авах эцсийн хугацаанаас хойш **45** хоногийн хугацаанд хүчинтэй байх ба та энэ хугацаа дуусахаас өмнө түүнийг сонгох боломжтой.
3. Гэрээг албан ёсоор байгуулах хүртэл энэхүү тендер болон түүнийг шалгарсан тохиолдолд гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэл нь бидний хооронд хийгдсэн хэлцэл болно.
4. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

Долоо. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- | | |
|---|---|
| 1. Гүйцэтгэгч ажил гүйцэтгэх | 1.1. Гүйцэтгэгч гэрээний тусгай нөхцөлд заасан ажлыг техникийн тодорхойлолт болон зургийн дагуу хийж гүйцэтгэнэ. |
| 2. Төслийн менежерийн шийдвэр | 2.1. Гэрээнд тусгайлан заагаагүй бол гэрээтэй холбогдсон аливаа асуудлыг захиалагчийг төлөөлөн төслийн менежер шийдвэрлэнэ. |
| 3. Ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр ажил дууссан байх | 3.1. Гүйцэтгэгч ажлыг гэрээний тусгай нөхцөлд заасан өдөр эхлүүлж, өөрийн гаргасан ажлын хөтөлбөр болон төслийн менежерийн баталсан тодотгосон ажлын хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэн, ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр дуусгана. |
| 4. Аюулгүй байдал | 4.1. Гүйцэтгэгч ажлын талбай дээрх бүх үйл ажиллагааны аюулгүй ажиллагааг хангаж ажиллана. 4.2. Барьж байгаа барилга, байгууламжаа байгалийн болзошгүй гамшиг, гэнэтийн аюулаас хамгаалах бүх талын арга хэмжээг авч, өөрийн нь ажилтай холбогдуулж барилгын болон байгаль орчин, эрүүл ахуй, гал түймрийн хяналтын албанаас гаргасан хууль ёсны шаардлага, дүгнэлтийг хүлээн авч биелүүлнэ. |
| 5. Зааварчилгаа | 5.1. Төслийн менежерийн гаргах аливаа зааварчилгаа нь Монгол улсын хууль, тогтоомжид нийцсэн байх бөгөөд түүнийг гүйцэтгэгч биелүүлэх үүрэгтэй |
| 6. Маргааныг шийдвэрлэх | 6.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана. |
| 7. Ажлын хөтөлбөр | Б. ХУГАЦААНЫ БОЛОН ЧАНАРЫН ХЯНАЛТ 7.1. Гүйцэтгэгч нь ажил гүйцэтгэхэд шаардлагатай бүх үйл ажиллагааны ерөнхий аргачлал, зохион байгуулалт, дэс дараалал, ажил гүйцэтгэх хугацаа болон бусад шаардлагатай мэдээллийг тусгасан ажлын хөтөлбөрийг боловсруулж, гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд төслийн менежерт хүргүүлж батлуулна. 7.2. Ажлын хөтөлбөрийг төслийн менежер батлах нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Гүйцэтгэгч нь ажлын хөтөлбөрийг хянан засварлаад төслийн менежерт хэдийд ч дахин хүргүүлж болно. Хянан засварласан ажлын хөтөлбөрт өөрчлөлтийг тусгана. |
| 8. Зөрчил, гологдол илрүүлэх | 8.1. Төслийн менежер гүйцэтгэгчийн ажлыг шалгаж, илэрсэн зөрчил, гологдлын талаар түүнд мэдэгдэнэ. Энэхүү шалгалт нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Төслийн менежер зөрчил, гологдол байж болзошгүй гэж үзсэн аливаа ажилд зөрчил, гологдол хайх, уг ажлын далд хэсгийг нээж шалгалт, туршилт явуулах талаар зааварчилгааг гүйцэтгэгчид өгөх эрхтэй. |
| 9. Зөрчил, гологдол арилгах | 9.1. Төслийн менежер гэрээний тусгай нөхцөлд заасан чанарын баталгаат хугацаа ¹ дуусахаас өмнө зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдлийг гүйцэтгэгчид өгнө. Чанарын баталгаат хугацааг зөрчил, гологдлыг арилгаж дуусах хүртэл сунгана. |

¹ Чанарын баталгаат хугацааг тогтоохдоо Иргэний хууль болон Барилгын тухай хуулийг баримтална.

- 9.2. Зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдэл өгсөн тухай бүр гүйцэтгэгч уг зөрчил, гологдлыг төслийн менежерийн мэдэгдэлд заасан хугацаанд багтааж өөрийн зардлаар арилгана.
10. Зөрчил, гологдол арилгахгүй байх
- 10.1. Хэрэв гүйцэтгэгч зөрчил, гологдлыг төслийн менежерийн мэдэгдэлд заасан хугацаанд багтааж арилгаагүй бол төслийн менежер зөрчил, гологдол арилгахад шаардагдах зардлыг тооцож гүйцэтгэгчээс гаргуулна.

В. ЗАРДЛЫН ХЯНАЛТ

11. Үе шатны ажлын хуваарь
- 11.1. Төслийн менежерийн шаардсаны дагуу гүйцэтгэгч үе шатны ажлын тодотгосон хуваарийг 14 хоногийн дотор бэлтгэж ирүүлнэ. Үе шатны ажлын хуваарьт тусгагдсан үйл ажиллагаа нь ажлын хөтөлбөрт тусгагдсан үйл ажиллагаатай нийцсэн байна.
- 11.2. Ажлын талбай дахь материалын төлбөрийг тусад нь хийх бол гүйцэтгэгч ажлын талбайд нийлүүлсэн материалын тооцоог үе шатны ажлын хуваариас тусад нь гаргаж ирүүлнэ.
12. Үе шатны ажлын хуваарийг өөрчлөх
- 12.1. Гүйцэтгэгчийн шийдвэрээр ажлын арга барил, эсхүл ажлын хөтөлбөрт гарсан өөрчлөлтийг тусгах зорилгоор гүйцэтгэгч үе шатны ажлын хуваарьт нэмэлт өөрчлөлт хийнэ. Өөрчлөлт хийхдээ үе шатны ажлын хуваарь дахь үнийг өөрчлөхгүй.
13. Алданги
- 13.1. Гүйцэтгэгч нь ажил дуусгахаар төлөвлөсөн өдрөөс хугацаа хоцорсон хоног тутамд гэрээний тусгай нөхцөлд заасан хувь хэмжээгээр алданги² төлнө. Алдангийн нийт дүн гэрээний тусгай нөхцөлд заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. Захиалагч нь алдангийг гүйцэтгэгчид төлөх төлбөрөөс суутган авч болно. Алданги төлсөн нь гүйцэтгэгчийн хүлээсэн үүрэг хариуцлагыг хөндөхгүй.

Г. ГЭРЭЭГ ДУУСГАХ

14. Ажил дуусгах
- 14.1. Гүйцэтгэгч нь ажил дууссан тухай мэдэгдэл гаргах хүсэлтийг төслийн менежерт тавих бөгөөд төслийн менежер ажил дууссан гэж үзвэл уг мэдэгдлийг гаргана. Гүйцэтгэгч гадна тохижилтын ажлыг бүрэн дуусгаж, ажлын явцад гудамж, зам, талбай сэтэлж, мод, цэцэрлэгжүүлэлтийг түр зайлуулсан бол эдгээрийг бүрэн хэмжээгээр сэргээсэн байна.
15. Хүлээж авах
- 15.1. Төслийн менежер ажил дууссан тухай мэдэгдэл гаргаснаас хойш захиалагч долоо хоногийн дотор ажлын талбай болон ажлыг хүлээж авна.
16. Эцсийн тооцоо
- 16.1. Гүйцэтгэгч гэрээний дагуу төлөгдөх ёстой гэж үзэж буй нийт төлбөрийн нарийвчилсан тооцоог гаргаж, чанарын баталгаат хугацаа дуусахаас өмнө төслийн менежерт хүргүүлнэ. Төслийн менежер зөрчил, гологдол арилгасан тухай мэдэгдэл гаргаж, хэрэв гүйцэтгэгчийн ирүүлсэн тооцоо бүрэн гүйцэд, үнэн зөв бол уг тооцоог хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор гүйцэтгэгчид төлөх эцсийн төлбөрийг тодорхойлно. Хэрэв тооцоо буруу байвал шаардлагатай залруулга, нэмэлт өөрчлөлтийн талаарх тайлбарыг 14 хоногийн дотор гаргаж гүйцэтгэгчид хүргүүлнэ. Хэрэв засвар хийж дахин ирүүлсэн эцсийн тооцоо нь шаардлага хангаагүй бол төслийн менежер гүйцэтгэгчид төлөх дүнг шийдвэрлэж төлбөрийн мэдэгдэл гаргана.

² Алдангийг ихэвчлэн хоногт 0.05-0.10 хувиар тогтоох бөгөөд нийт дүн нь гэрээний үнийн 5-10%-иас хэтрэхэсгүй.

- 17. Ашиглалт, засвар, үйлчилгээний гарын авлага**
- 17.1. Гүйцэтгэгч ажлын гүйцэтгэлийн зураг, далдлагдсан ажил, инженерийн шугам сүлжээ, технологийн тоног төхөөрөмжийг туршиж тохируулсан акт болон захиалагч шаардсан бол ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд хүлээлгэн өгнө.
- 17.2. Хэрэв гүйцэтгэгч 22.1-д заасан материалыг гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд ирүүлээгүй, эсхүл шаардлага хангаагүйн улмаас тэдгээрийг төслийн менежер батлаагүй бол гүйцэтгэгчид төлөх ёстой төлбөрөөс төслийн менежер гэрээний тусгай нөхцөлд заасан үнийн дүнг суутгана.
- 18. Гэрээг цуцлах**
- 18.1. Захиалагч, эсхүл гүйцэтгэгч нөгөө тал нь гэрээг ноцтой зөрчсөн гэж үзвэл гэрээг цуцлах эрхтэй.
- 18.2. Дор дурдсан нөхцөлүүдийг гэрээний ноцтой зөрчил гэж үзэх бөгөөд эдгээрээр хязгаарлагдахгүй:
- (а) ажлын хөтөлбөрт ажил зогсоох тухай заагаагүй, түүнчлэн ажил зогсоох тухай шийдвэрийг төслийн менежер батлаагүй байхад гүйцэтгэгч ажлыг 28 буюу түүнээс дээш хоногийн хугацаагаар зогсоосон;
 - (б) төслийн менежер ажлын явцыг зогсоох зааварчилгааг гүйцэтгэгчид өгсөн бөгөөд уг шийдвэрээ 28 хоногийн дотор цуцлаагүй;
 - (в) захиалагч, эсхүл гүйцэтгэгч дампуурсан, эсхүл өөрчлөн байгуулагдах, нэгдэхээс бусад зорилгоор татан буугдсан;
 - (г) тодорхой зөрчил, гологдлыг арилгаж чадаагүй нь гэрээний ноцтой зөрчил болохыг төслийн менежер гүйцэтгэгчид мэдэгдсэн бөгөөд гүйцэтгэгч нь уг зөрчил, гологдлыг заасан хугацаанд нь багтаан арилгаж чадаагүй;
 - (д) гүйцэтгэгч ажлын гүйцэтгэлийг гэрээний тусгай нөхцөлд заасан алдангийн дээд хэмжээ төлөх хугацаагаар хоцроосон.
- 18.3. Гэрээг цуцалсан тохиолдолд гүйцэтгэгч ажлыг даруй зогсоож, ажлын талбайн бүрэн бүтэн, аюулгүй байдлыг хангаж, түүнийг аль болох түргэн хугацаанд чөлөөлнө.
- 19. Гэрээг цуцалсан үед хийх төлбөр**
- 19.1. Гүйцэтгэгч гэрээг ноцтой зөрчсөний улмаас гэрээ цуцлагдсан бол төслийн менежер гүйцэтгэсэн ажлын болон захиалсан материалын үнэлгээг нотолсон мэдэгдэл гаргана. Ингэхдээ мэдэгдэл олгосон өдөр хүртэл дуусаагүй ажлын гэрээний тусгай нөхцөлд заасан хэмжээг дээрх үнэлгээнээс хасна. Нэмэлт алданги гүйцэтгэгчид ногдуулахгүй.
- 19.2. Гэрээг захиалагчийн шаардлагаар, эсхүл гэрээг захиалагч ноцтой зөрчсөний улмаас цуцалсан бол гүйцэтгэсэн ажлын болон захиалсан материалын үнэлгээ, тоног төхөөрөмжийг ажлын талбайгаас гаргах бодит зардал, ажлын зорилгоор хөлслөн ажиллуулсан гүйцэтгэгчийн ажилтнуудыг буцаахтай холбогдсон зардал, түүнчлэн ажлыг хадгалах, хамгаалахтай холбогдсон зардал зэрэг гүйцэтгэгчийн зардлыг төслийн менежер хянаж мэдэгдэл гаргана.

**20. Гүйцэтгэлээ
с чөлөөлөх**

20.1. Гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдлын улмаас гэрээг гүйцэтгэх боломжгүй болсон бол төслийн менежер үүнийг гэрчилнэ. Гүйцэтгэгч нь энэхүү мэдэгдлийг хүлээн авсны дараа ажлын талбайн бүрэн бүтэн байдлыг хангаж, ажлыг аль болох богино хугацаанд зогсооно. Захиалагч уг мэдэгдэл гарахаас өмнө хийгдсэн ажил болон түүний дараа захиалгаар гүйцэтгэсэн ажлын хөлсийг гүйцэтгэгчид төлнө.

Найм. **ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ**³

| | |
|-----------------|--|
| ГЕН 2.1 | Гэрээний нэр болон бүртгэлийн дугаар: Баатархайрхан өрхийн ЭМТ-ийн барилгыг цэвэр, бохирын шугамтай ХОАОНӨГ/202001155 |
| ГЕН 2.1 | Ажил нь <i>[товч тодорхойлолт, түүний дотор төслийн хүрээнд бусад гэрээтэй холбогдох байдал]</i> -аас бүрдэнэ. Ажлын талбай нь /Жаргалант сум Баатархайрхан баг байршил]-д байрших ба зураг №...-д зааснаар тодорхойлогдсон болно. |
| ГЕН 3.1 | Төслийн менежер нь |
| ГЕН 4.1 | Ажил эхлэх өдөр 2020.06.04 Ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр 2020.07.04 |
| ГЕН 7.1 | Гүйцэтгэгч гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдлийг хүлээн авснаас хойш 5 хоногийн дотор тодотгосон ажлын хөтөлбөрийг гаргана. |
| ГЕН 9.1 | Чанарын баталгаат хугацаа 365 хоног байна. |
| ГЕН 13.1 | Алданги ногдуулах хэмжээ хоногт гэрээний үнийн 0,1 хувь байна. Нийт ажилд ногдуулах алдангийн дээд хэмжээ нь гэрээний үнийн 5 хувь байна. |
| ГЕН 17.1 | Ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг 2020.07.04 -ний дотор гаргаж өгнө. Гүйцэтгэлийн зургийг 2020.07.04 -ний дотор гаргаж өгнө. Гүйцэтгэлийн зургийг, эсхүл ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг хугацаанд нь гаргаж өгөөгүй тохиолдолд суутгах төлбөрийн хэмжээ 100000 төгрөг байна. |
| ГЕН 19.1 | Ажил дуусгахад захиалагчаас гарах нэмэлт зардлыг дуусаагүй ажлын 0,1 хувь -иар тооцно. |

³ Захиалагч тендерийн баримт бичгийг тараахаас өмнө гэрээний тусгай нөхцөлийг бүрэн бөглөсөн байна. Захиалагчийн гаргах хуваарь, тайланг гэрээний тусгай нөхцөлд хавсаргана.

ГЭРЭЭНИЙ МАЯГТ

ЗАХИАЛАГЧ

ГҮЙЦЭТГЭГЧ

| | |
|-----------------|-----------------|
| _____ | _____ |
| (Тамга, тэмдэг) | (Тамга, тэмдэг) |
| _____ | _____ |
| (Гарын үсэг) | (Гарын үсэг) |
| _____ | _____ |
| (Албан тушаал) | (Албан тушаал) |

[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас [захиалагчийн нэр] (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас [гүйцэтгэгчийн хот, улс, гүйцэтгэгчийн нэр] (цаашид “гүйцэтгэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож _____ оны _____ сарын _____ -ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний хууль, Барилгын тухай хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу инженерийн хийцтэй барилга байгууламж барих, засварын ажил гүйцэтгэх, тоног төхөөрөмж суурилуулахтай холбогдон захиалагч, гүйцэтгэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.

2. Захиалагч нь [гэрээний нэр, дугаар]-г (цаашид “ажил” гэх) [гэрээний үнийг тоогоор болон үсгээр] (цаашид “гэрээний үнэ” гэх) гүйцэтгэхээр ирүүлсэн гүйцэтгэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ буюу ажлын нийт төсөвт өртөг нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.

3. Гэрээний нийт дүн: _____ төгрөг. Үүнээс: /Аль тохирохыг нь бөглөнө, бусдыг нь устгана/

Улсын төсвөөс: 20.... онд: _____ төгрөг; 20.... онд: _____ төгрөг;

Орон нутгийн төсвөөс: 20.... онд: _____ төгрөг; 20.... онд: _____ төгрөг;

Өөрийн хөрөнгө: 20.... онд: _____ төгрөг; 20.... онд: _____ төгрөг.

4. Гүйцэтгэгч нь _____ байршилтай _____ хүчин чадал бүхий _____ ам.метр талбай / _____ шоо метр эзлэхүүн/-тай, _____ суурь, _____ хана, _____ хучилттай, _____ давхар _____ барилга угсралт /барилгын засвар, тоног төхөөрөмж суурилуулах/-ын ажлыг _____ инженерийн шугам сүлжээ /дулаан, цахилгаан, цэвэр, бохир усан хангамж/, _____ туслах барилга /бусад ажил/-ын хамт _____ оны дугаар сарын _____ -ны өдөр эхэлж, _____ оны дугаар сарын _____ -ны өдөр ашиглалтад оруулна.

5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

- 5.1. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
- 5.2. Бусад шаардлагатай баримт бичиг ;
- 5.3. Үнийн санал
- 5.4. Гэрээний тусгай нөхцөл;
- 5.5. Гэрээний ерөнхий нөхцөл;
- 5.6. Техникийн тодорхойлолт;

- 5.7. Зураг;
- 5.8. Гүйцэтгэчийн ирүүлсэн үе шатны ажлын хуваарь ;
- 5.9. Санхүүжилтийн хуваарь;
- 5.10. Ажил гүйцэтгэх хуваарь.

Гэрээ нь энд дурдсан ажлыг гүйцэтгэх талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний бичиг баримтууд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Захиалагч, гүйцэтгэгч нь гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлд заасан эрх, үүрэг хүлээнэ.

7. Гүйцэтгэгч нь гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан ажлыг гүйцэтгэж, зөрчил, гологдол арилгах үүрэг хүлээнэ.

8. Захиалагч нь гэрээний дагуу гүйцэтгэгчийн хийх ажил болон зөрчил, гологдол арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний төлбөрийг гүйцэтгэгчид төлөх үүрэг, хүлээнэ.

9. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр болон утсан холбоогоор харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
[Гарын үсэг]_____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
[Гарын үсэг]_____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]